

R66, JU-6820 АГААРЫН ХӨЛГИЙН ХИЛИЙН БҮСЭД НИСЛЭГ ҮЙЛДСЭН ТУХАЙ

2021 оны 08-р сарын 29

АГААРЫН ХӨЛГИЙН ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАСАН ТАЙЛАН

2021 оны 10-р сарын 22



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
НИСЛЭГ-ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБА
AIRCRAFT ACCIDENT INVESTIGATION BUREAU,
MINISTRY OF ROAD & TRANSPORT DEVELOPMENT OF MONGOLIA

Aircraft Accident Investigation Bureau,
Ministry of Road and Transport Development
Nisekhiin Street, 10th khoroo, Khan-Uul
District
Ulaanbaatar 17120, Mongolia
Tel: (976) 71285011
(976) 9595-3399 (mobile)
Fax: (976) 70049974
E-mail: aaib@aaib.gov.mn
Website: www.aaib.gov.mn

Өмнөх үг

Энэхүү аюулгүй ажиллагааны шинжлэн шалгах ажиллагаа нь зөвхөн бодит үнэнийг тодорхойлох зорилготой бөгөөд Шинжлэн шалгах албаны тайлан нь уг тохиолдлын нөхцөл байдал болон байж болох шалтгаануудыг тогтооход оршино.

Олон улсын иргэний нисэхийн Конвенцийн Хавсралт 13, Монгол Улсын Иргэний нисэхийн тухай хуулийн [9-р бүлэг] болон Иргэний Нисэхийн Дүрэм 203-т заасны дагуу, шинжлэн шалгах ажиллагаа нь ямар ч тохиолдолд хэн нэгнийг буруутгах, хариуцлага тооцоход чиглэгдэхгүй. Шинжлэн шалгах ажиллагаа нь хэн нэгний гэм бурууг тогтоох, хариуцлага тооцох хууль хяналт, захиргааны арга хэмжээнээс ангид бие даасан, хараат бус байна. Шинжлэн шалгах ажиллагаа болон тайлангийн гол зорилго нь осол, зөрчлийг давтагдахаас урьдчилан сэргийлэхэд оршино.

Тайлангийн ишлэлийг ашиглахдаа эх үүсвэр нь тодорхой, агуулгыг гуйвуулахгүйгээр хэвлэн нийтэлж болох бөгөөд гутаан доромжлох, төөрөлдүүлэх зорилгоор ашиглахыг хориглоно.

Foreword

This safety investigation is exclusively of a technical nature and the Final Report reflects the determination of the AAIB regarding the circumstance of its occurrence and its probable causes.

In accordance with the provisions of Annex 13 to the Convention on International Civil Aviation, Civil Aviation Law of Mongolia [Chapter 9] and MCAR's 203.12, safety investigations are in no case concerned with apportioning blame or liability. They are independent of, separate from and without prejudice to any judicial or administrative proceedings to apportion blame or liability. The sole objective of this safety investigation and Final Report is the prevention of accidents and incidents.

Extracts from this Report may be published providing that the source is acknowledged, the material is accurately reproduced and that it is not used in derogatory or misleading context.

Тайлангийн дугаар/Report No: 2021.10.22/00.

Тайлангийн төрөл/Report Format: Эцсийн тайлан

Огноо/Published: 2021.10.22

In accordance with Annex 13 to the Convention on International Civil Aviation, Civil Aviation Law of Mongolia [Chapter 9] and MCAR's 203.12, the AAIB of Mongolia carried out an investigation into this incident.

Агаарын хөлгийн маяг/Helicopter Type: Robinson R66

Бүртгэлийн дугаар/Registration: JU6820

Хөдөлгүүрийн тоо, маяг /No. and Type of Engines: RR300/A1

Агаарын хөлгийн сериал / Helicopter Serial Number: 0797

Үйлдвэрлэсэн он/Year of Manufacture: 31.May.2017

Огноо, цаг/Date and Time: 2021.08.29, 16:00 (L)

Байршил/Location: Дорноговь 208 камп /Mongolia

Үйл ажиллагааны төрөл/Type of Operation: Зорчигч тээвэр – Хуваарьт бус нислэг / Charter flight

Хөлөгт байсан хүний тоо/Persons on Board: 4

Багийн гишүүн/Crew: 1, Зорчигч/Passengers: 3

Бэртсэн хүний тоо/Injuries: 0

Багийн гишүүн/Crew: 0 Зорчигч/Passengers: 0

Хохирлын хэмжээ/Nature of Damage: үгүй / not damage

Агаарын хөлгийн даргын гэрчилгээ/Commander's Licence: Тээврийн нисгэгчийн үнэмлэх / CPL

Агаарын хөлгийн даргын мэдээлэл/Commander's Details: Эрэгтэй, 55 настай / Male, 55 years old

Агаарын хөлгийн даргын туршлага/Commander's flying Experience: 4100 цаг /FH

Мэдэгдлийн эх сурвалж/Notification Source: Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний газар / ATC

Мэдээллийн эх сурвалж/Information Source: Утсаар / by phone

JU-6820, R66 АГААРЫН ХӨЛГИЙН ХИЛИЙН БҮСЭД НИСЛЭГ ҮЙЛДСЭН ЗӨРЧИЛ

Гарчиг / Table of contents/

Товчилсон үгс

Товч мэдээлэл /Executive summary/

1. БОДИТ МЭДЭЭЛЭЛ /Factual information/
 - 1.1. Нислэгийн түүх /History of the flight/
 - 1.2. Нисгэгчийн мэдээлэл/Pilot information/
 - 1.3. Агаарын хөлгийн мэдээлэл /Aircraft information/
 - 1.3.1. Их бие /Airframe/
 - 1.3.2. Хөдөлгүүр /Engine/
 - 1.3.3. Бусад /Other/
2. ДҮН ШИНЖИЛГЭЭ /ANALYSIS/
 - 2.1. Нислэгийн төлөвлөлт
 - 2.2. Нислэг / Flight /
3. ДҮГНЭЛТ /CONCLUSION/
 - 3.1. Илэрсэн нөхцөл/Findings/
 - 3.2. Боломжит шалтгаан/Probable causes/
4. АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨМЖ /SAFETY RECOMMENDATION/
 - 4.1. Аюулгүй ажиллагааны шинэ зөвлөмж /New safety recommendations/
 - 4.2. Өмнө өгсөн аюулгүй ажиллагааны зөвлөмж /Previously issued safety recommendations/

Товчилсон үгс

АТ	- Агаарын тээвэрлэгч
БНХАУ	- Бүгд Найрамдах Хятад Ард Улс
НТОЗШША	- Нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба
НМА	- Нислэгийн мэдээллийн ажилтан
НМТ	- нислэгийн мэдээллийн төв
НХУ	- нислэгийн хөдөлгөөний удирдагч
ИНЕГ	- Иргэний нисэхийн ерөнхий газар
ИНД	- Иргэний нисэхийн дүрэм
НХҮА	- Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба
ОНХМҮХ	- Орон нутгийн нислэгийн мэдээллийн үйлчилгээний хэсэг
ХХК	- Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХЦ	- Хилийн цэрэг
УБ	- Улаанбаатар
РН	- район
ЭХАТМЗХ	- эрэн хайх авран туслах мэдээлэл зохицуулалтын хэлтэс
AF	- Airframe
ATPL	- Air Transport Pilot Licence
AFM	- Aircraft flight manual
AMM	- Aircraft maintenance manual
P/N	- Part number
PP	- Powerplant
QRH	- Quick reference handbook
S/N	- Serial number
TAF	- Terminal Area Forecast
TGB	- Tail rotor gearbox
TT	- Total time
FH	- Flight hours

**JU6820, R66 АГААРЫН ХӨЛГИЙН ХИЛИЙН
БҮСЭД НИСЛЭГ ҮЙЛДСЭН ТУХАЙ****Товч мэдээлэл /Executive summary/**

Иргэний нисэхийн ерөнхий газрын Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба/НХҮА/-ны Эрэн хайх, авран туслах мэдээлэл зохицуулах хэсэг /ЭХАТМЗХ/-ийн 71281622 утсанд 2021.08.29-ний өдөр Зэвсэгт Хүчний 303-р ангийн нислэгийн хөдөлгөөний зохицуулагч ахлах дэслэгч Гантулга холбогдож “БНХАУ-ын хилийн цэргийн газраас манай улсын Хилийн цэргийн 0131 ангитай холбогдож, Монгол Улсын талаас Хилийн 704-р багана (Өмнөговь аймгийн Гашуун сухайт боомтын ойролцоох)-ын районд 2021.08.29-ний өдрийн 15.00 цагийн үед мөнгөлөг өнгөтэй нисдэг тэрэг зөвшөөрөлгүй хил нэвтэрсэн байж болзошгүй” гэсэн мэдээлэл өгсөн байна.

Дээрх мэдээллийн дагуу НХҮА-ны Орон нутгийн нислэгийн мэдээллийн үйлчилгээний хэсэг/ОННМҮХ/-ийн Туул ажлын байрны мэдээллийн ажилтан нь Монголиан Эйрвейс ХХК-ний оперэйшнээс MGW1275 аялалын дугаартай нислэгийн талаар асуухад Шивээ уулын районд 10.15 цагт буусан, дахин нислэг хийгээгүй гэсэн байна. Мөн НХҮА-ны ЭХАТМЗХ-ээс тухайн өдөр явагдаж байгаа нислэгийг шалгахад Өмнөговь аймаг болон БНХАУ-тай урд хилээр зааглагдсан аймгуудад нисдэг тэрэгний нислэг байхгүй байсан гэж тэмдэглэсэн байна.

Тухайн өдрийн 15.30 цагт Ханбумбат нисэх буудлын ажилтан нь НХҮА-ны нислэгийн мэдээллийн үйлчилгээний Туул ажлын байр руу залгаж “манай нисэх буудал дээгүүр жижиг онгоц яваад өнгөрлөө, манайх руу нислэг байсан уу” гэж асуусан байна. Нислэгийн мэдээллийн үйлчилгээний Туул ажлын байрны Нислэгийн мэдээллийн ажилтан/НМА/ нь Монголиан Эйрвэйз ХХК-ний оперэйшн руу залгаж MGW1275 талаар асуухад манай онгоц хөөрөөгүй, Шивээ уулын райондаа байгаа гэсэн бөгөөд өөр нислэг тухайн районд байхгүй тул энэ талаар Ханбумбат нисэх буудалд мэдэгдсэн гэж тэмдэглэсэн байна.

НХҮА-ны ЭХАТМЗХ-ийн зохицуулагч нь 2021.08.29-ний 20.45 цагт НТОЗШША-ны жижүүрийн утсаар холбогдож дээрх мэдээллийг өгчээ.

2021.08.30-ны өдрийн 06.30 цагт Зэвсэгт Хүчний 303-р ангийн нислэгийн хөдөлгөөний зохицуулагч ахлах дэслэгч Гантулга нь ЭХАТМЗХ-ийн утас руу ярьж, хил нэвтэрсэн байж болзошгүй нисдэг тэргийг Дундговь аймгийн Өлзийт сумын Тагт багт, Шивээ уулын районд хоноглож байгаа MGW1275 дуудлагатай, JU-6820 улсын бүртгэлийн дугаартай R66 маягийн нисдэг тэрэг байж болзошгүй тул Хилийн Цэргийн 0131 ангиас шалгалтын ажил хийгдэж байна гэсэн мэдээллийг өгчээ.

MGW1275 дуудлагатай, JU-6820 улсын бүртгэлийн дугаартай R66 маягийн нисдэг тэрэг нь ИНЕГ-ын 2021 оны 08 сарын 29-ний өдрийн Хоногийн нислэгийн

төлөвлөгөөнд Хар Усан Тохой /УБ, Гачуурт/ – Шивээ Уул Район – Хар Усан Тохой чиглэлд захиалгат нислэг үйлдэхээр тусгагдсан байсан байна.

2021.08.29-ний өдөр MGW1275 дуудлагатай, JU-6820 улсын бүртгэлийн дугаартай R66 маягийн нисдэг тэрэг нь Хар Усан тохойгоос 07.22 цагт нислэг эхлээд Шивээ уулын районд 10.15 цагт буусан, хоноглохоор болсон, өөр нислэг үйлдэхгүй гэж Монголиан Эйрвейс ХХК-ний оперэйшнээс НХҮА-ны НМҮ-ний Туул ажлын байр /ЭХАТМЗХ/-нд мэдээлэл өгсөн байна.

НТОЗШША-аас дээрх мэдээллийн дагуу Өмнөговь аймгийн Хилийн Цэргийн 0131 ангийн Хил хамгаалах тасгийн дарга хошууч Гансүх /утас: 88067040/-тэй утсаар холбогдож дараах мэдээллийг авсан болно. Үүнд:

Улаанбаатарын Гачууртаас нислэг үйлдсэн JU-6820 нисдэг тэрэг нь 2021.08.29-ний өдөр Таван толгой, Гашуун сухайтын төмөр замын ажил хийгдэж байгаа газрын дагуу нислэг үйлдэхдээ улсын хилийн зурвас руу зөвшөөрөлгүй нислэг үйлдэж улсын хилийн 704 дүгээр багана, Гашуун сухайт боомтоос 15 километрийн зайд ойртсон. Уг нисдэг тэргээр Бодь-Интернэйшнл ХХК-ийн гүйцэтгэх захирал Долгормаа нисч байсан бөгөөд ХЦ-ийн 0131 ангиас холбогдох шалгалтыг хийж энэ зөрчлийг тогтоосон байгаа гэв.

Хил хамгаалах ерөнхий газрын 2021.09.01-ний өдрийн 2/1508 албан бичигт:БНХАУ-ын талаас хилийн төлөөлөгчийн шугамаар “2021 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 16.30 цагт хилийн 704 дүгээр тэмдгийн чиглэлээр цагаан өнгийн нисдэг тэрэг 5000 м өндрөөр нислэг үйлдэж *улсын хилд тулаад зүүн зүг эргэж ниссэнийг* агаарын довтолгооноос хамгаалах цэрэг илрүүлсэн” гэж тэмдэглэсэн байна.

1. БОДИТ МЭДЭЭЛЭЛ /Factual information/

1.1. Нислэгийн түүх /History of the flight/

Иргэний нисэхийн ерөнхий газрын Нислэгийн урсгал төлөвлөлтийн албаны 2021.08.29-ний өдрийн хоногийн нислэгийн төлөвлөгөөний орон нутгийн хуваарьт бус нислэгийн төлөвлөгөөнд:

аялалын дугаар:	MGW1275/ MGW1276		
нисэн гарах буудал/цаг:	Хар усан тохой район	/	07:00,
нисэн очих буудал/цаг:	Шивээ уул район	/	10:15,
нисэн гарах буудал/цаг:	Шивээ уул район	/	14:15,
нисэн очих буудал/цаг:	Хар усан тохой район	/	17:00,
нислэгийн зорилго:	ерөнхий зориулалтын гэж тусгасан байна.		


Монголиан Эйрвейс ХХК-ийн 2021.08.29-ний өдрийн нислэгийн төлөвлөгөөнд:

Аялалын дугаар	MGW1275/ MGW1276		
Хөөрөх газрын нэр/коорд/ нисэх цаг	Хар усан тохой рн	/	07:00
	N47 53.0 E 107 08.0		
Буух газрын нэр/ буух цаг	Шивээ уул рн	/	09:45

Хөөрөх газрын нэр/коорд/ нисэх цаг	Шивээ уул рн	/	14:15
	N44 14.1 E 106 01.0		
Буух газрын нэр/ буух цаг	Хар усан тохой рн	/	17:00
Нислэгийн зорилго	Хувийн гэж тусгасан байна.		

Аялалын MGW1275 дугаартай JU-6820, R66 агаарын хөлөг 2021.08.29-ний өдрийн 7.22 цагт Хар Усан Тохой /Улаанбаатар, Гачуурт/-аас нисэн гарч, 10.15 цагт Шивээ уулын район /Дундговь, Өлзийт сум, Цагаан суврага/-д буусан байна.

Нисгэгчийн болон бусад мэдүүлэгээс үзэхэд энэ өдөр Шивээ уулын районоос нисэн гарч 11.30 цагт Таван толгойн өртөө, Дэмчиг уулын орчим/43 160 26N, 107 120 33E/-д бууж 16.30 цагийн орчимд 208 дугаар камп-д нисэн очсон ба уг газраас 18.00 цагт нисэн гарч, 18.45 цагт Шивээ уулын районд бууж хоноглон байна.



Зураг 1. төлөвлөгдсөн нислэг хар, төлөвлөгдөөгүй нислэг улаан

Нислэгийн гүйцэтгэлийн хөтлөлт/Flight Log Book/-д дараах тэмдэглэгээ хийгдсэн байна.Үүнд:

08.29-нд, River-Gobi desert, зорчигч 3, нислэгийн цаг 5.8, буулт 5
08.30-нд, Gobi desert- River, зорчигч 3, нислэгийн цаг 2,5, буулт 1

1.2. Нисэх багийн мэдээлэл /Flight crew information/

1.2.1. Агаарын хөлгийн дарга /Pilot in Command/

2021.08.29-ний өдрийн MGW1275 дугаартай аялалын JU-6820, R66 агаарын хөлгийн даргаар томилогдсон нисгэгч нь Канад улсын иргэн, 55 настай, Канад улсын эрх бүхий байгууллагаас олгогдсон арилжааны нисгэгчийн CH728591 дугаартай үнэмлэхтэй, үнэмлэхний хүчинтэй хугацаа 2025.11.01-н хүртэл байна. Нисгэгч нь A109,BH06,BH427,EN28,HGCG2,HL12,HU30,R66,RH22,RH44 маягийн нисдэг тэргээр нисэх эрхтэй, нийт ниссэн цаг 4100 байна. Нисгэгчийн гадаад улсаас олгогдсон үнэмлэхийг Монгол Улсын Иргэний нисэхийн ерөнхий газар баталгаажуулан/Certificate of validation/, HU30, AS350, EC130, R44, R66 маягийн нисдэг тэрэгээр нисэх эрх олгосон байна. Баталгаажуулалтын хүчинтэй хугацаа 2021.09.26 хүртэл, эрүүл мэндийн гэрчилгээний хүчинтэй хугацаа 2021.12.17 байна. Баталгаажуулалтыг хийхэд Aviation air law in English –ээр 15 асуулттай шалгалт авч 80 %-ийн үзүүлэлтээр тэнцүүлсэн байна.

1.2.2. Хамтран нисгэгч /Co-pilot/

(нислэгийн ашиглалтын зааврыг үндэслэн нэг гишүүнтэй нислэг үйлдсэн байна.)

1.3. Агаарын хөлгийн мэдээлэл /Aircraft information/

1.3.1. Их бие /Airframe/

Registration: JU-6820		Date of Manufacture	TT at delivery	TTSN	Landing at delivery	Total landing
Helicopter type	Robinson R66	31.May.2017	4.01	130	32	309
Manufacturer serial number	0797					

Хүснэгт 1. Их биений үндсэн мэдээлэл

1.3.2. Хөдөлгүүр /Engine/

Registration: JU-6820		Date of Manufacture	TT at delivery	TTSN	Total cycles at delivery	Total cycles
Engine type	RR300/A1	31.May.2017	4.01	130	32	309
Manufacturer serial number	RRE-200807					

Хүснэгт 2. Хөдөлгүүрийн үндсэн мэдээлэл

1.3.3. Бусад мэдээлэл /other/



Зураг 2. JU-6820 бүртгэлийн дугаартай R66 маягийн агаарын хөлөг

1	Engine	Rolls Royce RR300 Turbine
2	Horsepower	300 shp turboshaft, derated to 270 shp for takeoff and 224 shp continuous
3	Maximum Gross Weight	2700 lb (1225kg)
4	Approximate Empty Weight (including oil & standard)	1200 lb (585kg)
5	Fuel Capacity (73.6gal)	493 lb (224kg)
6	Pilot, Passengers, and Baggage (with maximum)	917 lb (416kg)
7	Cruise Speed at Maximum Gross Weight	Up to 110 kts (204km/h)
8	Maximum Range (no reserve)	Approximately 350 nm (650km)
9	Maximum Operating Altitude	14000 ft
10	Electrical System	28 volt
11	Number of Seats	2+3

Хүснэгт 3. R66 маягийн агаарын хөлгийн техникийн үзүүлэлт

2021.05.21-нд Иргэний нисэхийн ерөнхий газраас Монгол Улсын Иргэний нисэхийн дүрэм 21-ийн В-д тусгагдсан стандарт категорид заасан маягийг хүлээн зөвшөөрөх гэрчилгээний шаардлагуудыг хангасан

гэж үзээд ROBINSON HELICOPTER COMPANY-ийн Robinson R66 загварт №2/21B/21 дугаартай “Агаарын хөлгийн маягийг хүлээн зөвшөөрсөн гэрчилгээ/Type acceptance certificate/-г олгосон байна.

2021.07.01-нд Иргэний нисэхийн ерөнхий газраас Агаарын тээвэрлэгч ROBINSON HELICOPTER COMPANY-ийн Robinson R66 маягийн, 0797 үйлдвэрлэлийн дугаартай агаарын хөлгийг Монголын Нисэхийн Академи ХХК-ийн нэр дээр Агаарын хөлгийн бүртгэлийн № 797/21 дугаартай гэрчилгээгээр үндэсний JU6820 таних тэмдгийг олгосон байна.

2021.07.02-нд Иргэний нисэхийн ерөнхий газрын Нислэгт тэнцэх чадварын хэлтэсээс тогтоосон ашиглалтын хязгаарлалтад уг агаарын хөлгийн техник үйлчилгээ ба ашиглалт нь нийцсэн Нислэгт тэнцэх чадвартай гэж үзээд JU6820 бүртгэлийн таних тэмдэгтэй, Robinson R66, үйлдвэрлэлийн 0797 дугаартай агаарын хөлөгт Нислэгт тэнцэх чадварын №797 CA/21 дугаартай гэрчилгээг олгосон байна.

Иргэний нисэхийн ерөнхий газраас Монголиан Эйрвейс ХХК нь “Иргэний нисэхийн тухай” Монгол Улсын хууль ИНД-119, ИНД-135 болон компанийн үйл ажиллагааны зааврын дагуу уг гэрчилгээний хавсралт болон үйл ажиллагааны тодорхойлолтонд тусгагдсан хязгаарлалтуудын хүрээнд арилжааны агаарын тээврийн үйл ажиллагаа явуулах эрхтэй болохыг тодорхойлж АТ-030 дугаартай АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧИЙН ГЭРЧИЛГЭЭ/Air Operator Certificate/-г 2020.07.10-нд олгосон, хүчинтэй хугацаа 2023.07.09 хүртэл байна.

Гэрчилгээний Үйл ажиллагааны тодорхойлолтын “А 01. Үйлчлэх хүрээ болон олголт”-д АТ-030 тоот гэрчилгээ эзэмшигч нь Иргэний нисэхийн тухай монгол улсын хууль болон бусад хуулиуд, ИНД-135 болон ИНЕГ-аас гаргасан дүрэм, журамд нийцүүлэн үйл ажиллагаа явуулах эрхтэйгээр олгосон байна.

Гэрчилгээний Үйл ажиллагааны тодорхойлолтын “А03. зөвшөөрөгдсөн агаарын хөлгүүд”-д Robinson R66, үйлдвэрлэлийн дугаар 0797, улсын бүртгэлийн дугаар JU-6820 хамаарч байна.

Гэрчилгээний Үйл ажиллагааны тодорхойлолтын “А04. Зөвшөөрөл болон хязгаарлалт”-д зөвхөн дараах үйл ажиллагааг гүйцэтгэхийг зөвшөөрсөн байна. Үүнд:

- Зорчигч, ачаа тээвэр
- Дадлага сургалтын нислэг
- Эмнэлгийн түргэн тусламж
- Эрэн хайх, авран хамгаалах нислэг
- Захиалгат

2. ДҮН ШИНЖИЛГЭЭ/ANALYSIS/

2.1. Нислэгийн төлөвлөлт

Иргэний нисэхийн ерөнхий газрын Нислэгийн урсгал төлөвлөлтийн албаны 2021.08.29-ний өдрийн хоногийн нислэгийн төлөвлөгөөний орон нутгийн хуваарьт бус нислэгийн төлөвлөгөөнд MGW1275/ MGW1276 аялалын дугаартай нислэгийн зорилгыг **ерөнхий зориулалтын** гэж тэмдэглэсэн байхад Монголиан Эйрвейс ХХК-ийн 2021.08.29-ний өдрийн нислэгийн төлөвлөгөөнд уг нислэгийн зорилгыг **хувийн** гэж тэмдэглэсэн байна.


Иргэний нисэхийн ерөнхий газрын Нислэгийн урсгал төлөвлөлтийн албаны 2021.08.29-ний өдрийн хоногийн нислэгийн төлөвлөгөөний орон нутгийн хуваарьт бус нислэгийн төлөвлөгөөнд бусад багтаамж багатай агаарын хөлгүүдийн нислэгийн зорилгыг ерөнхий зориулалтын гэж тэмдэглэсэн байна.

Монголиан Эйрвейс ХХК-ийн 2021.08.29-ний өдрийн нислэгийн төлөвлөгөөнд MGW1275/ MGW1276 аялалын дугаартай нислэгийн зорилгыг хувийн гэж тэмдэглэсэн нь Агаарын Тээвэрлэгчийн Гэрчилгээний Үйл ажиллагааны тодорхойлолтын “A04. Зөвшөөрөл болон хязгаарлалт”-д тусгагдсан нислэгийн зөвшөөрөлтэй нийцэж байгаа эсэх нь тодорхойгүй байна.

2.2. Нислэг

2021.08.29-ний өдрийн JU6820, Robinson R66 маягийн агаарын хөлгийн Шивээ уулын район-Таван толгойн өртөө-Дэмчиг уулын орчим-208 дугаар камп-Шивээ уулын районд хийсэн нислэгүүд нь хоногийн нислэгийн төлөвлөгөөнд тусгагдаагүй, агаарын хөлгийн дарга нислэгийн хөдөлгөөний аль нэг удирдлагад болон компанийн нислэгийн ажиллагааны зохицуулагчид тус тус мэдэгдээгүй байна.

JU6820, Robinson R66 агаарын хөлгийн сүүлд буюу хилд ойр буусан 208 дугаар камп нь Гашуун сухайтын хилийн боомтоос 10 км, Монгол Улсын хилийн хамгийн ойр цэгээс 7.3 км зайд байна.



Зураг 3. Хилийн зурваст ойртсон байршил

3. ДҮГНЭЛТ /CONCLUSIONS/

3.1. Илэрсэн нөхцөл

Монголиан Эйрвейс ХХК-ийн JU6820, R66 агаарын хөлөг нь Иргэний нисэхийн дүрэм 135-ийн Агаарын тээвэрлэгчийн үйл ажиллагааны хүрээнд ашиглагдахаар зохицуулагдсан байна.

Монголиан Эйрвейс ХХК-ийн JU6820, R66 агаарын хөлөг 2021.08.29-ний өдрийн хоногийн нислэгийн төлөвлөгөөний дагуу нислэг үйлдээгүй байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын болон компанийн төлөвлөлтөнд нислэгийн зорилгыг тодорхой тусгаагүйгээс нислэгийг төлөвлөлт болон нислэгийн хөдөлгөөний зохицуулалт хийх нөхцөл боломж бүрдээгүй байна.

Монголиан Эйрвейс ХХК-ийн JU6820, R66 агаарын хөлөг Ханбумбат нисэх буудлын дээгүүр D ангилалын агаарын зайд холбоо барилгүй нислэг үйлдсэн байна.

JU6820, R66 агаарын хөлгийн холбогдогчийг Агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээнд эзэмшигч нь Монголын нисэхийн академи ХХК гэсэн ба Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээнд тээвэрлэгч нь Монголиан Эйрвейс ХХК гэж тус тус тодорхойлсон нь хариуцагч нь тодорхой бус байна.

JU6820, Robinson R66 агаарын хөлгийн сүүлд буюу хилд ойр буусан 208 дугаар камп нь Гашуун сухайтын хилийн боомтоос 10 км, Монгол Улсын хилийн хамгийн ойр цэгээс 7.3 км зайд байгаа нь “Агаарын зайг нисэхэд ашиглах тухай Монгол Улсын хууль”-ийн 4.1.2-т “Хилийн агаарын бүс/улсын хилийн шугамаас дотогш 30км-ын өргөнтэй нутаг дэвсгэр дээрх агаарын зай/” гэсэн заалтад хамаарагдаж байна.

Монголиан Эйрвейс ХХК-ийн JU6820, R66 агаарын хөлгийн 2021.08.29-ний өдрийн нислэг “Агаарын зайг нисэхэд ашиглах тухай Монгол Улсын хууль”-ийн 8 дугаар зүйл Агаарын зайн зөрчил-ийн 8.1.4-т (**Монгол улсын хилийн агаарын бүсэд зөвшөөрөлгүй нислэг үйлдэх**) гэсэн заалт зөрчсөн байна.

Монголиан Эйрвейс ХХК-ийн JU6820, R66 агаарын хөлгийн 2021.08.29-ний өдрийн нислэг Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын 2010 оны 6 дугаар сарын 10-нд байгуулсан гэрээний 21-рт (**Талууд хилийн шугамаас өөрийн тал руу 25 км-ийн бүс дотор агаараас зураг авах, хэмжилт хийх , агаарын хөлөг нислэг үйлдэх тохиолдолд 15-аас доошгүй хоногийн өмнө нөгөө Талдаа дипломат шугамаар урьдчилан мэдэгдэнэ**) гэсэн заалт зөрчсөн байна.

Иргэний нисэхийн дүрэм/ИНД-71/-т болон бусад холбогдох баримт бичиг, Нислэгийн мэдээллийн эмхтгэл/НМЭ/-д “Агаарын зайг нисэхэд ашиглах тухай Монгол Улсын хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.1.4-р заалт болон Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын 2010 оны 6 дугаар сарын 10-нд байгуулсан гэрээний 21-р заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбогдсон тодорхой зохицуулалт хийгдээгүй байна.

Монголиан Эйрвейс ХХК-нь Иргэний нисэхийн дүрмийн дараах заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

- Иргэний нисэхийн дүрэм 91-ийн 91.225. (а)-ийн 1/ заалт ...НХУ албатай тогтоосон давтамж дээр хоёр талын радио холбоо барина.
- Иргэний нисэхийн дүрэм 91-ийн 91.129. Хязгаарлалттай болон аюултай бүсэд нислэг үйлдэх, (а) заалт

- Иргэний нисэхийн дүрэм 119-ийн 119.119. Нислэгийн зөвшөөрөл болон хяналт, (а) заалт
- Иргэний нисэхийн дүрэм 119-ийн 119.121. Нислэгийн хяналтын үйлчилгээ, (а) ба (б) заалт
- Иргэний нисэхийн дүрэм 135-ын 135.53. Багийн гишүүдийн нийтлэг хэл(а) Гэрчилгээ эзэмшигч нь дараах зүйлсийг бататгасан байна.
1/ нисгэх багийн гишүүд нийтлэг нэг хэлээр харилцан ойлголцох ба нисэх багийн аль нэг гишүүн нислэгийн хөдөлгөөний хэллэгээр ойлголцдог байх;
2/ нэг нисгэгч бүхий агаарын хөлгийн гишүүн монгол хэлээр зохих түвшинд харилцан ойлголцох боломжгүй тохиолдолд НХУ-ын мэргэжлийн операторыг оролцуулах;
- Нислэг үйлдэх бүсийн батлагдсан нислэгийн газрын зураг тухайн нислэгт байхгүй байна.

3.2. Боломжит шалтгаан/Probable causes/

Хятадын талын мэдэгдэл/хилийн цэргийн албан бичигт дурьдагдсан/, нисгэгчийн мэдүүлэг болон сансрын байршил тогтоогч /GPS/-д тэмдэглэгдсэн мэдээллээс үзэхэд Монголиан Эйрвейс ХХК-ийн JU6820 бүртгэлийн дугаартай R-66 агаарын хөлөг хилд ойр 208 дугаар кампид зүүн эргэлт хийж буухад Монгол Улсын хилээс 6-7 км орчим зайд ойртсон нь “Агаарын зайг нисэхэд ашиглах тухай Монгол Улсын хууль”-ийн 4.1.2-т “Хилийн агаарын бүс/улсын хилийн шугамаас дотогш 30км-ийн өргөнтэй нутаг дэвсгэр дээрх агаарын зай/”-д нэвтэрсэн байна.

Иргэний нисэхийн дүрэм/ИНД-71/-т болон бусад холбогдох баримт бичиг, Нислэгийн мэдээллийн эмхэтгэл /НМЭ/-д “Агаарын зайг нисэхэд ашиглах тухай Монгол Улсын хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.1.4-р заалт болон Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын 2010 оны 6 дугаар сарын 10-нд байгуулсан гэрээний 21-р заалтуудтай холбогдсон тодорхой зохицуулалт хийгдээгүй болон Монголиан Эйрвейс ХХК-ийн JU6820 бүртгэлийн дугаартай R66 агаарын хөлгийн дарга нислэгийн төлөвлөгөөнд тусгагдаагүй нислэг үйлдсэн нь хилийн агаарын бүс түүний хязгаарлалтуудыг зөрчих үндсэн шалтгаан болж байна.

4. АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨМЖ /SAFETY RECOMMENDATION

4.1. Аюулгүй ажиллагааны шинэ зөвлөмж /New safety recommendations/

Аюулгүй ажиллагааны зөвлөмж ИНЕГ. 202109/13 Иргэний нисэхийн холбогдох дүрэм, Нисэхийн Мэдээллийн Эмхэтгэл /НМЭ/-д “Агаарын зайг нисэхэд ашиглах тухай Монгол Улсын Хууль”-ийн 4.1.2. заалт болон Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын 2010 оны 6 дугаар сарын 10-нд байгуулсан гэрээний 21-р заалттай холбогдол бүхий мэдээллийг тусгах.

Аюулгүй ажиллагааны зөвлөмж ИНЕГ. 202109/14 Гадаад улсын харьяат нисгэгчийг Монгол Улсад нислэг үйлдэх эрх, үнэмлэх олгох болон баталгаажуулахад тавигдах шаардлагыг боловсронгуй болгох тусгай хөтөлбөр, заавар боловсруулж хэрэгжүүлэх.

4.2. Аюулгүй ажиллагааны өмнө өгсөн зөвлөмж /Previously issued safety recommendations/

Зөвлөмж 201308/16 Иргэний нисэхийн ерөнхий газар Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын 2010 оны 6 дугаар сарын 10-нд байгуулсан гэрээний дагуу Хятад, Монголын хилийн орчимд хилийн шугамаас өөрийн тал руу 25 км-ийн бүс дотор агаараас зураг авах, хэмжилт хийх, агаарын хөлөг нислэг үйлдэх тохиолдолд эрх бүхий байгууллагаас дипломат шугамаар Хятадын талд мэдэгдсэн мэдэгдлээс хойш 15-аас доошгүй хоногийн дараа нислэг үйлдэх зөвшөөрлийг олгож байх.

Зөвлөмж 201308/17 Иргэний нисэхийн ерөнхий газар хилийн бүс орчимд нислэг үйлдэхтэй холбогдсон харилцааг зохицуулах дүрэм, зааврыг Монгол улсын хууль, хөрш орнуудтай хийсэн гэрээ хэлцэл, бусад эрх зүйн баримт бичигт нийцүүлэн боловсруулан мөрдөж ажиллах.

Олон улсын иргэний нисэхийн Конвенцийн Хавсралт 13, Монгол Улсын Иргэний нисэхийн тухай хуулийн [9-р бүлэг] болон Иргэний Нисэхийн Дүрэм 203-т заасны дагуу, шинжлэн шалгах ажиллагааны гол зорилго нь осол, ноцтой зөрчил давтагдан гарахаас урьдчилан сэргийлэхэд оршино. Аливаа ослыг шинжлэн шалгасан үйл ажиллагаа болон түүнтэй холбоотой тайлан нь хэн нэгнийг буруутгах, хариуцлага тооцох зорилгогүй.

Аюулгүй ажиллагааны зөвлөмж нь тухайн хэрэг явдалд хэн нэгнийг буруутгах, хариуцлага тооцох дүгнэлт гаргах үндэслэл болохгүй.

In accordance with Annex 13 to the Convention on International Civil Aviation, Civil Aviation Law of Mongolia [Chapter 9] and Mongolian Civil Aviation Rule's, the sole purpose of this investigation is to prevent aviation accidents and serious incidents. It is not the purpose of any such investigation and the associated investigation report to apportion blame or liability.

A safety recommendation shall in no case create a presumption of blame or liability for an occurrence.

Produced by the Aircraft Accident Investigation Bureau of Mongolia

AAIB Reports are available on the website at www.aaib.gov.mn

Aircraft Accident Investigation Bureau,
Ministry of Road and Transport
Nisekhiin Street, 10th khoroo
Khan-Uul District
Ulaanbaatar 17120
Mongolia
Tel: (976) 71 285011
(976) 9595-3399 (mobile)
Fax: (976) 70049974
E-mail: aaib@aaib.gov.mn
Website: www.aaib.gov.mn